



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 21 өдөр

Дугаар А/355

Хэрлэн сум

Тэмдэглэлт ойн зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.21, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 204 дүгээр “Журам батлах” тухай тогтоолоор батлагдсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэн өнгөрүүлэх журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.4-т заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газрын харьяа “Бор-Өндөр” Уулын баяжуулах үйлдвэрийн газарт 50 жилийн ойг тэмдэглэх зөвшөөрөл олгосугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Гантулга)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ЧОГСОМЖАВ